

МАХГАЛЫН “УРИН ЗАЛЛАГА”-ЫН ЭГШИГ ТЭМДЭГЛЭГЭЭНД ХИЙСЭН ШИНЖЛЭЛ

П.Даваапил

Хураангуй: Буддын шашны гурав дахь дэлгэрэлтээс хойш арван хангал тэргүүтэй догшдын тахилга, Будда Шагжамүни тэргүүтэй арван зүг гурван цагийн бурхдын магтаалыг ая дантай уншдаг болсон байна. Түүгээр ч барахгүй тэдгээрийн ая данг тусгай зурлага, тэмдгээр бичиж үлдээжээ. Буддын шашны эдгээр ая дантай уншдаг зан үйлийн судалгаа төдийлөн их биш байна. Ялангуяа ая дангийн эгшиг тэмдэглэгээг найруулга, эгшиг томолттой нь холбогдуулан судалсан ажил ховор байна. Тиймээс энэхүү өгүүлэлд Махгалын “Урин заллага”-ын хэсэг дэх эгшиг тэмдэглэгээг найруулга, эгшиг томолттой нь уялдуулан судлахыг зорилоо. Ингэхдээ “Шанхын Баруун хүрээ хийд”, “Гандантэгчэнлин хийд”, “Ламын гэгээний хийд”, “Зүүн хүрээ Дашчойлин хийд”-ийн догшдын тахилгын судрын хэсгийг гол эх сурвалжаа болголоо.

Түлхүүр үг: *Эгшиг тэмдэглэгээ (dbyangs yig, notation), Махгал (Maha kala), Гомбо (mgon po), Найруулга, Эгшиг томолт*

Оршил

Махгалын ая данг тэмдэглэсэн судар, гар бичмэлүүд, тэдгээрт буй зурлага, эгшиг тэмдэглэгээний тухай дараах өгүүлүүд хэвлэгджээ. Доктор Д.Даваасүрэн “Нэгэн зүйл янгийн судрын мэдээ” өгүүлэлдээ “dpal ye shes mgon po'i mdzad rgyun 'khrul med byin rlabs can gyi dbyangs yig rol yig dang bcas pa bzugs so” буюу “Цогт билгэ билгүүнт Гомбын уншлага эндүүрэл үгүй адистэд бүхий эгшиг тэмдэглэгээ, хөгжмийн тэмдэглэгээ лүгээ сэлт оршвой” нэрт сударт, “Эгшиг тэмдэглэгээг түлхүүрдэх боломж ба хэдэн мэдээний утга” өгүүлэлдээ “mkhan chen chos kyi rgyal po'i mdzad pa'i dam can chos kyi rgyal po'i dbyangs yig bzugs so” буюу “Их ханба Номун хааны зохиосон тангарагтан Номын хааны эгшиг тэмдэглэгээ оршвой”, “dpal ye shes mgon po'i mdzad rgyun 'khrul me byin rlabs can gyi dbyangs yig dang bcas pa bzugs so” буюу “Цогт бэлгэ билгүүн Гомбын зохиолын үргэлжлэл эндүүрэл үгүй адистэдийн эгшгийн тэмдэглэгээ, хөгжмийн тэмдэглэгээ сэлт оршвой” нэрт судруудад тус тус шинжлэл хийжээ. Тухайн судар, гар бичмэлийн онцлог, түүнд буй мэдээ баримт, зурлага тэмдэглэгээ болон Гомбын тахилгын бүтэц дарааллын тухай өгүүлсэн байна. Г.Төвшинтөр, Б.Соронзонболд нар “Махагалын урин заллагын их ян Ганганлам”, “Гомбо сахиусны урин заллагын шинжигмаан ян “Ганга лам хэмээх” оршвой” сэдэвт өгүүлэлдээ Махагалын урин заллагын их янгийн гарал үүсэл, шинэ хуучин хэмээхийн учир, хурлыг ая дантай уншихын ач тус, утга бэлгэдэл, нууц тарнийн ёстой хэрхэн холбогддог болох, ямар дэс дараатай уншдаг болохыг тэмдэглэсэн судрыг орчуулан тайлбарласан байна. Мөн Г.Төвшинтөр “Махгалын уншлагын ян татах ёсыг хөгжмийн онолын үүднээс судлах нь” сэдэвт магистрын зэрэг горилсон бүтээлдээ орчин цагийн өрнөдийн хөгжмийн онолын ойлголтуудын үүднээс задлал хийжээ. Гэсэн хэдий ч Махгалын “Урин заллага”-ыг сонгон өөр өөр хийдэд хадгалагдаж ирсэн судар, гар бичмэлүүд дэх зурлага, эгшиг тэмдэглэгээг найруулгатай нь уялдуулан судалсан судалгаа байхгүй байна.

Үндсэн хэсэг

Махгал (Санскрит: Mahakala, төвөд: mgon po, монгол: Их хар) хэмээх нь санскрит нэр нь бөгөөд Монголд төвөд нэрээр нь мөн Гомбо бурхан гэж хэлэлцдэг. Маш олон дүртэй, олон дагуултай бурхан бөгөөд Авалокитешвара бурханы хувилгаан, түүний догшин дүр гэж үздэг. “Төвөд оронд Төвөдийн Сакиаба ёсныхон Гомбо гүр бурхныг өөрсдийн шашны гол сахиусаар, Гарма гаржүдба шашинд Бэрнаг Махагалыг, Шарын шашны арван хангал бурхдын нэгэнд зургаан мутарт Махагала бурхныг тус тус нэн эрхэмлэн шүтдэг билээ” (Баясгалан, 2011: 116). Юань гүрний үед Хубилай хаан Пагва ламыг улсын багшаар өргөмжилж, сажагийн ёсны Гомбо гүрийг шүтүүлэх болжээ. Энэ уламжлал эдүгээ Эрдэнэзуу хийдэд хадгалагдан үлдсэн байх бөгөөд гол шүтээн нь Гомбо гүр бурхан хэвээр байна. Хожим III далай лам Содномжамц Түмэдийн алтан ханд Шарын шашны зургаан мутарт Махгал бурхныг монголчууд нийтээрээ шүтэхийг зарлигдсан бөгөөд эдүгээ дэлгэр шүтэж буй нь энэхүү зургаан мутар Махгал байна. Үүнийг судар шастир, музей, сүм хийд дэх шүтээн зургуудаас бэлхнээ харж болно. Ийнхүү хамгийн түгээмэл дүрслэгдсэн, шүтэгдэж ирсэн нь зургаан мутарт Махгал юм. “Махгал” буюу “Гомбо”-ын их янг жилд нэг удаа өвлийн адаг сарын шинийн хорин долоонд Гомбо, Шалши яам -тай өдөр тахидаг байна. Махгал тэргүүтэн номыг тэтгэгчдийг тахиж буй уншлагын бүтэц, дараалал нь дараах байдалтай байна. Үүнд:

1. “Жандэн” /тө: spyen ‘dren, мон: урин заллага/
2. “Чодба” /тө: mchod pa, мон: тахил/
3. “Нанчод” /тө: nang mchod, мон: дотоод тахил/
4. “Солдэв” /тө: gsol btab, мон: залбирал/
5. “Шагба” /тө: bshags pa, мон: наманчилга/
6. “Гаанс” /тө: thugs dam bskang ba, мон: хангал/
7. “Прэнжал” /тө: ‘phrin bcot, мон: /
8. “Гүл” /тө: bskul, мон: дуртгах/
9. “Дайв” /тө: bzlas pa, мон: давтан өгүүлэх/
10. “Дорма” /тө: gtor ma, мон: балин/
11. “Додба” /тө: bstod pa, мон: магтаал/
12. “Ансол” /тө: mnga’ gsol, мон: / эдгээр орно.

Урин заллага хэмээх нь тухайн бурхныг өөрийнх нь оршдог орноос дуудан ирүүлж буй хэсэг бөгөөд “Махагала шүтэгчид хэрэгтэй цагтаа дуудаж ирүүлээд өргөл өгч аргадан, хатуу шаардлага тавьж, хүн, малд тохиолдсон элдэв гай гамшгийг буцаах буюу устган дарах” (Баясгалан, 2011: 120)-ын тулд урин дуудаж буй хэсэг юм. “Тахилгын зан үйлийг үйлдээчин нь сахиуснуудыг өмнийн агаартаа үүсгэн бясалгаж буйгаар уг зан үйлийн уншлага эхэлж байна. Эл үесийн уншлага нь үргэлжилсэн үгээр зохиогдсон бөгөөд удаавтар, сүрлэг өнгө аясаар уншигддаг. Ингэхдээ Гомбо, Гонгорыг тус тус “зүүн урд Силби-цал гэх үхээрийн орон дахь нэгэн зандан модны өмнөөс...” (Эртний дуу хөгжмийн... 2015: 66) урин залдаг ажээ. Дээрх хоёр баримтаас үзвэл Махгал бурхныг өөрийнх нь оршдог “Сэрүүн цэцэрлэг” хэмээх газраас урин залж тахилгын оронд дуудан ирүүлж байна. Өөрөөр хэлбэл Махгалын орон буюу тахилга үйлдэж буй сүм, дуган, орон хийдэд залан авчирч буй хэрэг мөн. Махгалын “Урин заллага”-ын дөрвөн шад нь:

“ХУМ шэн-жиг шэн-жиг чой-жи ин-най-шэн,
Чой ин нам даг анлай маёо жан,
Дүгба дүлчир тово гүрдан ба


Лха-чэн ма-ха ка-ла жан-дэн-но” хэмээх мөр бүрдээ есөн үетэй эл хэсэг юм. “Хоёр мөрөөс зургааг хүртэл амны уншлагад барилдуулваас нэг шүлэг, түүн дор даган сайшаагч

хэмээх найман үеийг төвөдөд долоог нэг мөр гэх тэргүүтэн аль зохистойн тийн агуулгад үйлдээрэй. Ихэнх аялгуутай үг нь долоо, ес зэрэг тэнцүү, эсхүл тэнцүү биш байсан ч болно” (Агваангунгаасодном, 2014: 53) хэмээсэнтэй тохирч байна. “ХУМ” хэмээх нь хөрөнгө үсэг юм. “Очирт тааллын хөрөнгө үсгийг “Хум”-аар бэлгэдэх бөгөөд “Хум” үсэг нь Бурханы таалал, амгалан хоосон ялгалгүйн таван билиг билгүүнтэй холбогдоно” (Төвшинтөр, Соронзонболд, 2013: 58) гэжээ. Энэ хэсгийн зурлага, эгшиг тэмдэглэгээг “Шанхын Баруун хүрээ хийд”, “Гандантэгчэнлин хийд”, “Ламын гэгээний хийд”, “Зүүн хүрээ Дашчойлин хийд”-ийн судар, гар бичмэлүүдэд хэрхэн тэмдэглэсэн, хэрхэн найруулсан, яаж эгшиг томсныг тодруулахын тулд эдгээрийг тус бүрд нь шинжилье.


Шанхын Баруун хүрээний Махгалын “Урин заллага”-ын эгшиг тэмдэглэгээг (Зураг-1а,б,в) доор үзүүлээ. Бид хоёрдугаар бүлгийн хоёрдугаар зүйлд эгшиг тэмдэглэгээг “Хөгжмийн шастар”, “Хөгжмийн шастирын тайлбар”, “Их хүрээний ая эгшигийн уг гарал” дахь дөрвөн аялгуу, зургаан төгөлдөр, арван үлгэртэй холбоотой бөгөөд Махгалын тахилгын зан үйлийг горимынх нь дагуу гүйцэтгэж буй энэ үйл явц нь үг, эгшиг, хөгжимдүүр тэдгээрийн найруулга гэж үзэж болно. Тиймээс эдгээрийг хамт төрсөн хөгжмийн дөрвөн зүйл аялгуу, зургаан төгөлдөр, арван үлгэр, найруулгад нь тулгуурлан тайлбарлая.



Зураг-1а. Шанхын Баруун хүрээний эгшиг тэмдэглэгээ



Зураг-1б. Шанхын Баруун хүрээний эгшиг тэмдэглэгээ



Зураг-1в. Шанхын Баруун хүрээний эгшиг тэмдэглэгээ

Энд хоёр янзын уламжлалт ноот байна. Нэгдүгээрт “Эгшиг тэмдэглэгээ”-г улаан болон хар бэхэн зураасаар “Урин заллага”-ын шүлгийн дээд талд давхарлан зурсан, хоёрдугаарт бусад шалтгаанаас гарсан хөгжмийн тэмдэглэгээний нэг төрөл болох “Цангийн тэмдэглэгээ”-г хар бэхээр дугуй дүрсээр “Урин заллага”-ын шүлгийн доод талд тэмдэглэсэн байна. Тодруулбал, татахыг , нугалахыг , цохихыг , өргөхийг , буулгахыг 


эдгээр зурлагуудаар тэмдэглэсэн байна. Харин  тэмдэглэгээ нь цангийн тэмдэглэгээ юм.

Найруулга нь “хум” гэх үгийг хэлэн татаад үргэлжлүүлэн “но” гэж эгшиг томоод “шэн” гэх үгийг хэлэн цан цохин татаад үргэлжлүүлэн “нэ” гэж эгшиг томоод “жиг” гэх үгийг хэлэн цан цохин татаад “гэ” гэж эгшиг томоод “шэн” гэх үгийг хэлэн цан цохин татаад үргэлжлүүлэн “нэ” гэж эгшиг томоод “жиг” гэх үгийг хэлэн цан цохин татаад “чой” гэх үгийг хэлэн цан цохин татаад, хоолой цохиод буулгаад буцааж өргөжээ. “Жи” гэх үгийг хэлэн цан цохин татаад


“и” гэж эгшиг томоод “ин” гэх үгийг хэлэн цан цохин татаад хоолой цохиод татахдаа “нэ” гэж эгшиг томоод “най” гэх үгийг хэлэн цан цохин татаад “шэн” гэх үгийг хэлэн цан цохин татаад үргэлжлүүлэн “хэ” гэж эгшиг томоод буулгаад, нугалаад буцааж өргөхдөө “а” гэх эгшгээр эгшиг томжээ. “чой” гэх үгийг хэлэн цан цохин татаад “са” гэж эгшиг томоод “ин” гэх үгийг хэлэн цан цохин татаад “нэ” гэж эгшиг томоод “нам” гэх үгийг хэлэн цан цохин татаад “даг” гэх үгийг хэлэн татаад “sogs” буюу “тэргүүтэн” гэсэн утга бүхий үгийг төвөдөөр бичжээ. Энэ нь “анлай маёо жан, дүмба дүлчир тово гүрдан ба, лха-чэн ма-ха ка-ла” гэх үгийг дээрхийн адил татаарай” хэмээн товчилсон хэрэг болов уу. Учир нь үүний араас “жан” гэх үгийг хэлэн цан цохин татаад “на” хэмээн эгшиг томоод “дэн” гэх үгийг хэлэн цан цохин хоолой цохиод буулгаад “нэ” гэж эгшиг томон татаад “но” гэх үгийг хэлэн цан цохиод буулгажээ. Энэ сударт эгшиг томолтыг тэмдэглэхдээ үндсэн үгээс нь тусад нь “нго”, “гэ”, “са”, “и”, “хэ”, “а”, “на”, “нэ” “но” зэрэг нэмэлт үе бичжээ.

Сударт тэмдэглэсэн дээрх хэсгийг татахдаа 17 удаа цан цохино гэсэн байна. Өөрөөр хэлбэл “шин”, “жиг”, “шин”, “жиг”, “чой”, “жи”, “ин”, “най”, “шэн”, “хэ”, “чой”, “ин”, “нам”, “даг”, “жан”, “дэн”, “но” гэх үгсийг хэлэх үед цан цохихыг тодорхой тэмдэглэжээ. Гурван удаа буулгах, хоёр удаа өргөх, гурван удаа хоолой цохих, хоёр удаа нугалах, хорин зургаан удаа татахыг тэмдэглэсэн зурлага байна.

Гандантэгчэнлин хийдийн Махгалын “Урин заллага”-ын эгшиг тэмдэглэгээг (Зураг-2а,б) доор үзүүлэв.



Зураг-2а. Гандантэгчэнлин хийдийн эгшиг тэмдэглэгээ



Зураг-2б. Гандантэгчэнлин хийдийн эгшиг тэмдэглэгээ

Энд хоёр янзын уламжлалт ноот байна. Нэгдүгээрт “Ян-ег” буюу “Эгшиг тэмдэглэгээ”-г хар болон улаан бэхэн зураасаар “Урин заллага”-ын шүлгийн дунд давхарлан зурсан, хоёрдугаарт бусад шалтгаанаас гарсан хөгжмийн тэмдэглэгээний нэг төрөл болох “Цангийн тэмдэглэгээ”-г улаан бэхээр “Урин заллага”-ын шүлгийн доод талд нь тэмдэглэсэн байна. Татахыг [image],

нугалахыг [image], өргөхийг [image], цохихыг [image], буулгахыг [image] эдгээр зурлагуудаар

тэмдэглэсэн байна. Харин [image] энэ нь цангийн тэмдэглэгээ юм.

Найруулга нь “хуно” гэх үгийг хэлэн татаад “шэ-нэ” гэх үгийг хэлэхдээ цан цохин татаад “жи-гэ” гэх үгийг хэлэн цан цохиод буулгажээ. “Чой” гэх үгийг хэлэн цан цохиод хоолой цохиод буулгаад нугалаад өргөөд буцааж нугалаад “жи-и” гэх үгийг хэлэн цан цохиод буулгажээ. “Ин-нэй” гэх үгийг хэлэн цан цохиод татаад “най” гэх үгийг хэлэн цан цохиод “шэн” гэх үгийг хэлэн цан цохиод татаад “хэ” гэх үгийг хэлэн цан цохиод хоолой цохиод буулгаад нугалаад өргөөд буцааж нугалаад “чой” гэх үгийг хэлэн цан цохиод татаад “ин” гэх үгийг хэлэн цан цохиод татаад “нам” гэх үгийг хэлэн цан цохиод татаад “даг” гэх үгийг хэлэн цан цохиод буулгажээ. Цааш нь “zhes bshad gcig gi dbyangs mjug tu” буюу “хэмээх нэг шадны аялгууны төгсгөлд” гэж бичжээ. Тэгээд “жан” гэх үгийг хэлэн цан цохиод татаад “дэн” гэх үгийг хэлэн цан цохиод өргөөд татаад хоолой цохиод буулгаад “но” гэх үгийг хэлэн цан цохижээ. Энэ сударт эгшиг томолтыг тэмдэглэхдээ үндсэн үгтэй нь залган гол үсгийн дараагийн дагавар дээр “о”, “э”, “и” зэрэг эгшгүүд бичжээ. Хоёрдугаар мөр эхлэхийн өмнө нэг удаа “хэ” хэмээх нэмэлт үе бичжээ.


Сударт тэмдэглэсэн дээрх хэсгийг татахдаа 17 удаа цан цохино гэсэн байна. Өөрөөр хэлбэл “шин”, “жиг”, “шин”, “жиг”, “чой”, “жи”, “ин”, “най”, “шэн”, “хэ”, “чой”, “ин”, “нам”, “даг”, “жан”, “дэн”, “но” гэх үгсийг хэлэх үед цан цохихыг тодорхой тэмдэглэжээ. Хамгийн эхний

цан цохих тэмдэглэгээний өмнө улаан бэхээр дөрвөн цэг  тэмдэглэсэн байна. Найман удаа буулгах, гурван удаа өргөх, гурван удаа хоолой цохих, дөрвөн удаа нугалах, арван хоёр удаа татахыг тэмдэглэсэн зурлага байна.

Ламын гэгээний хийдийн Махгалын “Урин заллага”-ын эгшиг тэмдэглэгээг (Зураг-3а,б) доор үзүүлэв.



Зураг-3а. Ламын гэгээний хийдийн эгшиг тэмдэглэгээ



Зураг-3б. Ламын гэгээний хийдийн эгшиг тэмдэглэгээ

Энд хоёр янзын уламжлалт ноот байна. Нэгдүгээрт “Ян-ег” буюу “Эгшиг тэмдэглэгээ”-г хар болон улаан бэхэн зураасаар “Урин заллага”-ын шүлгийн дээр болон дунд нь давхарлан зурсан, хоёрдугаарт бусад шалтгаанаас гарсан хөгжмийн тэмдэглэгээний нэг төрөл болох “Цангийн тэмдэглэгээ”-г улаан бэхээр “Урин заллага”-ын шүлгийн доод талд нь тэмдэглэсэн байна. Цаасны зүүн дээд талд хөх балаар “mgon po” буюу “Гомбо” хэмээн бичсэн байна.

Татахыг , нугалахыг , өргөхийг , цохихыг , буулгахыг




 эдгээр зурлагуудаар тэмдэглэсэн байна. Харин  энэ нь цангийн тэмдэглэгээ юм.


Найруулга нь “хуно” гэх үгийг хэлэн цан цохиод татаад “шэн” гэх үгийг хэлэн цан цохиод татаад “жиг” гэх үгийг хэлэн цан цохиод татаад “шэн” гэх үгийг хэлэн цан цохиод татаад “жиг” гэх үгийг хэлэн цан цохиод буулгажээ. “Чой” гэх үгийг хэлэн цан цохиод хоолой цохиод буулгаад нугалаад өргөөд нугалаад буулгаад “жи” гэх үгийг хэлэн цан цохиод хоолой цохиод буулгажээ. “Жин” гэх үгийг хэлэн цан цохиод татаад “най” гэх үгийг хэлэн цан цохиод буулгаад “шэн” гэх үгийг хэлэн цан цохиод өргөжээ. “Хэ” гэх үгийг хэлэн цан цохиод хоолой цохиод буулгаад нугалаад өргөөд нугалаад буулгаад “чой” гэх үгийг хэлэн цан цохиод татаад “ин” гэх үгийг хэлэн цан цохиод “нам” гэх үгийг хэлэн цан цохиод татаад “даг” гэх үгийг хэлэн цан цохиод буулгажээ. Цааш нь “zhes pa nas” буюу “хэмээснээс” гэж бичжээ. Тэгээд “жан” гэх үгийг хэлэн цан цохиод татаад “дэн” гэх үгийг хэлэн цан цохиод хоолой цохиод буулгаад нугалаад өргөөд “но” гэх үгийг хэлэн цан цохиод буулгажээ. Энэ гар бичмэлд эгшиг томолтыг тодорхой тэмдэглээгүй байх бөгөөд хоёрдугаар мөр эхлэхийн өмнө нэг удаа “хэ” хэмээх нэмэлт үс бичжээ.

Сударт тэмдэглэсэн дээрх хэсгийг татахдаа 18 удаа цан цохино гэсэн байна. Дээрх хоёр судраас ялгаатай нь эхний “хум” хэмээх үгийг хэлэх үед цан цохиж байна. Бусад “шин”, “жиг”, “шин”, “жиг”, “чой”, “жи”, “ин”, “най”, “шэн”, “хэ”, “чой”, “ин”, “нам”, “даг”, “жан”, “дэн”, “но” гэх үгсийг хэлэх үед цан цохихыг тэмдэглэсэн нь адил байна. Арван удаа буулгах, дөрвөн удаа өргөх, дөрвөн удаа хоолой цохих, таван удаа нугалах, найман удаа татахыг тэмдэглэсэн зурлага байна.


Зүүн хүрээ Дашчойлин хийдийн Махгалын “Урин заллага”-ын эгшиг тэмдэглэгээг (Зураг-4а,б,в) доор үзүүлэв.



Зураг-4а. Зүүн хүрээ Дашчойлин хийдийн эгшиг тэмдэглэгээ





Зураг-4б. Зүүн хүрээ Дашчойлин хийдийн эгшиг тэмдэглэгээ



Зураг-4в. Зүүн хүрээ Дашчойлин хийдийн эгшиг тэмдэглэгээ

Энд хоёр янзын уламжлалт ноот байна. Нэгдүгээрт “Ян-ег” буюу “Эгшиг тэмдэглэгээ”-г хар болон улаан бэхэн зураасаар “Урин заллага”-ын шүлгийн дунд нь давхарлан зурсан, хоёрдугаарт бусад шалтгаанаас гарсан хөгжмийн тэмдэглэгээний нэг төрөл болох “Цангийн тэмдэглэгээ”-г улаан бэхээр “Урин заллага”-ын шүлгийн доод талд нь тэмдэглэсэн байна.

Татахыг , нугалахыг , өргөхийг , цохихыг , буулгахыг  эдгээр зурлагуудаар тэмдэглэсэн байна. Харин  энэ нь цангийн тэмдэглэгээ юм.

Найруулга нь “хуно” гэх үгийг хэлэн цан цохиод татаад “шэн” гэх үгийг хэлэн цан цохиод татаад “нэ” гэж эгшиг томоод татаад “жиг” гэх үгийг хэлэн цан цохиод татаад буулгаад “шэн” гэх үгийг хэлэн цан цохиод татаад “нэ” гэж эгшиг томоод татаад “жиг” гэх үгийг хэлэн цан цохиод буулгажээ. “Чой” гэх үгийг хэлэн цан цохиод хоолой цохиод буулгаад нугалаад өргөөд “жи” гэх үгийг хэлэн цан цохиод хоолой цохиод буулгажээ. “Ин” гэх үгийг хэлэн цан цохиод татаад “най” гэх үгийг хэлэн цан цохиод татаад “шэн” гэх үгийг хэлэн цан цохиод буулгажээ. Цааш нь “nas” буюу “aas” гэх үгийг бичээд үргэлжлүүлэн “хэ” гэх үгийг хэлэн цан цохиод хоолой цохиод буулгаад нугалаад өргөөд “лха” гэх үгийг хэлэн цан цохиод татаад “ла” гэж эгшиг томоод татаад “чэн” гэх үгийг хэлэн цан цохиод татаад “нэ” гэж эгшиг томоод татаад “ма” гэх үгийг хэлэн цан цохиод татаад “ва” гэж эгшиг томоод татаад “ха-и” гэх үгийг хэлэн цан цохиод буулгажээ. “Га” гэх үгийг хэлэн цан цохиод хоолой цохиод буулгаад нугалаад өргөөд “ла-и” гэх үгийг хэлэн цан цохиод хоолой цохиод “жан” гэх үгийг хэлэн цан цохиод өргөөд буулгаад “дэн” гэх үгийг хэлэн цан цохиод хоолой цохиод буулгаад нугалаад өргөөд “но” гэх үгийг хэлэн цан цохиод буулгажээ. Энэ сударт эгшиг томолтыг “нго”, “нгэ”, “ла”, “нэ”, “ва”, “и”, “хэ” хэмээн заримыг нь үндсэн үгтэй нь залган, заримыг нь тусад үе болгон бичжээ.

Сударт тэмдэглэсэн дээрх хэсгийг татахдаа 20 удаа цан цохино гэсэн байна. Эхний “хум” хэмээх үгийг хэлэх үед цан цохиж байна. Мөн “лха”, “ма”, “чэн”, “ха”, “га”, “ла” гэх үгсийг хэлэх үед цан цохиж байна. Дээрх гурван судраас ялгаатай нь “чой”, “ин”, “нам”, “даг” гэх үгсийг цангийн цохилгын хамт бичээгүй байна. Бусад “шин”, “жиг”, “шин”, “жиг”, “чой”, “жи”, “ин”, “най”, “шэн”, “хэ”, “жан”, “дэн”, “но” гэх үгсийг хэлэх үед цан цохихыг тэмдэглэсэн нь адил байна. Есөн удаа буулгах, таван удаа өргөх, зургаан удаа хоолой цохих, таван удаа нугалах, арван дөрвөн удаа татахыг тэмдэглэсэн зурлага байна.

Хэл хоолойн урлал, цангийн тэмдэглэгээ/ СУДАР	ШАНХЫН БАРУУН ХҮРЭЭНИЙ СУДАР ДАХЬ ЗУРЛАГА, ТОО	ГАНДАНТЭГЧЭНЛИН ХИЙДИЙН СУДАР ДАХЬ ЗУРЛАГА, ТОО	ЛАМЫН ГЭГЭЭНИЙ ХИЙДИЙН СУДАР ДАХЬ ЗУРЛАГА, ТОО	ЗҮҮН ХҮРЭЭ ДАШЧОЙЛИН ХИЙДИЙН СУДАР ДАХЬ ЗУРЛАГА, ТОО
Татах	 26	 12	 8	 14
Нугалах	 2	 4	 5	 5
Өргөх	 2	 3	 4	 5
Цохих	 3	 3	 4	 6
Буулгах	 3	 6	 10	 8
Цангийн тэмдэглэгээ	 17	 17	 18	 20

Махгалын “Урин заллага”-ын хэсэг дэх хэл хоолойн урлалыг тэмдэглэсэн зурлага, цангийн тэмдэглэгээний харьцуулсан хүснэгт

Дээрх хүснэгтээс харвал “Шанхын Баруун хүрээний сударт” татах нь олонх байна. Энэ нь “Ямар ч сахиусны тахилын уншлагын янгийн хэв маяг нь мөрний эхэн, адагт бага зэргийн урвуулах, долгиулах янз оруулаад, их бие нь шулуухнаар үгийг аажуухан цувуулан татдагийг энд тэмдэглэх нь зүйтэй” (Даваасүрэн, 2013: 180) хэмээсэнтэй таарч байна. Өөрөөр хэлбэл тухайн мөрийн эхэн болон төгсгөлд хоолой цохих нь элбэг байна. Харин “Эгшиг тэмдэглэгээний шастир дахь улаан шунхан болон хар бэхэн хэл хоолойн хөдөлгөөний дүрст тэмдэглэгээ нь хамт төрсөн хөгжмийн хэмнэлийн тэмдэглэгээ мөн” (Төвшинтөр, 2019: 48) гэсэн нь эргэлзээ төрүүлж байна. Дээрх нь зурлага, түүний найруулгаас харвал эдгээр нь аялгууг хэрхэн найруулах, хэл хоолойгоорой ямар урлал үйлдэхийг зааж байгаа нь тодорхой байна.

Эндээс дараах дүгнэлтүүд гарч байна. Үүнд:

- “Ян-ег” буюу “Эгшиг тэмдэглэгээ”-г Шанхын Баруун хүрээний сударт “Урин заллага”-ын шүлгийн дээр нь, Гандантэгчэнлин хийд, Зүүн хүрээ Дашчойлин хийдийн сударт дунд нь, Ламын гэгээний хийдийн сударт дунд нь болон дээр нь тус тус тэмдэглэсэн байна. Энэ нь тухайн судар, гар бичмэлийг бичиж тэмдэглэсэн хүнийх нь онцлог уу, ая эгшгийн найруулгынх нь онцлог уу гэдгийг лавшруулан судлах хэрэгтэйг харуулж байна.
- Цангийн цохилгыг “Шанхын баруун хүрээ”-ний сударт хар бэхээр, бусад гурван сударт нь улаан бэхээр тэмдэглэсэн байна. “Шанхын Баруун хүрээ” болон “Гандантэгчэнлин хийд”-ийн сударт тус бүр 17, “Ламын гэгээний хийд”-ийн сударт 18, “Зүүн хүрээ Дашчойлин

хийд”-ийн сударт 20 ширхэг цангийн тэмдэглэгээ байна. Дээрх дөрвөн сударт “шин”, “жиг”, “шин”, “жиг”, “чой”, “жи”, “ин”, “най”, “шэн”, “хэ”, “жан”, “дэн”, “но” гэх үгсийг хэлэх үед бүгдэд нь цан цохиж байна. “Ламын гэгээний хийд”, “Зүүн хүрээ Дашчойлин хийд”-ийн сударт “хум” гэх үгийг хэлэх үед цан цохиж байхад “Шанхын Баруун хүрээ” болон “Гандантэгчинлэн хийд”-ийн сударт “хум” гэх үгийг хэлэх үед цан цохихгүй байна. Хөрөнгө үсгийг татах үед цан цохих эсэхийг тухайн хийдийн горим, бусад сурвалжуудаас тодруулах хэрэгтэй байна.

- Дээрх сурвалжуудад “Урин заллага”-ын шүлгийн дөрвөн шад дахь “ан-лай ма-ёо жан, дүг-ба дүл-чир то-во гүр-дан ба, лха-чэн ма-ха ка-ла” гэх үгсийн эгшиг тэмдэглэгээг тэмдэглэлгүй товчилсон байна. Энэ нь өмнөх аялгуутай адил тул товчилжээ. Өөрөөр хэлбэл нэгдүгээр мөрийн эхлэл буюу “h’um bzhengs-shig bzhengs-shig” гэх хэсгийн аялгуу нь өөр, дундах мөрүүд буюу “chos-kyi dbyings-nas-bzhengs, Chos-dbyings rnam-dag ngang-las ma-gyos-kyang, gDug-pa ‘dul-phyir khro-bo’i skur-bstan-pa, lha-chen ma-h’a ka’-la” хэмээх мөрүүдийн аялгуу нь өөр, сүүлийн “spyen-‘dren-no” хэмээхийн аялгуу өөр байна. Тиймээс энэ дөрвөн сударт үүнийг товчлон “sogs” буюу “тэргүүтэн”, “zhes bshad gcig gi dbyangs mjug tu” буюу “хэмээх нэг шадны аялгууны төгсгөлд”, “zhes pa nas” буюу “хэмээснээс” “nas” буюу “аас” хэмээн ялгаатай тэмдэглэжээ. Угтаа эхэн “А”, дунд “В” төгсгөл “С” гэсэн гурван өөр аялгуутай дөрвөн шад байна гэсэн үг юм.

- “Урин заллага”-ын шүлэгт байхгүй тодрхой утга илэрхийлэхгүй нэмэлт үе, эгшгүүд сударт бичигджээ. Тодруулбал, Шанхын Баруун хүрээний сударт “нго”, “гэ”, “са”, “хэ”, “на”, “нэ”, “но” зэрэг нэмэлт үе, “и”, “а” зэрэг нэмэлт эгшиг гарч ирж байна. Гандантэгчинлин хийдийн сударт “хэ” гэх нэмэлт үе, “э”, “и” зэрэг нэмэлт эгшиг гарч ирж байна. Ламын гэгээний хийдийн сударт “хэ” хэмээх нэмэлт үеийг эс тооцвол эгшиг томолтыг тэмдэглэсэн эгшиг, нэмэлт үе байхгүй байна. Зүүн хүрээ Дашчойлин хийдийн сударт “нго”, “хэ” “ла”, “нэ”, “ва” “га” зэрэг нэмэлт үе гарч ирсэн байна. Энэ нь эгшиг томолтыг тэмдэглэхдээ үндсэн үгтэй нь хамт эгшгээр амилуулсан, нэмэлт үе бичсэн, эгшиг томолтыг тэмдэглээгүй гэх гурван янз буйг илтгэж байна.

- Нугалахад хамаарах , өргөхөд хамаарах , буулгахад хамаарах зэрэг өвөрмөц зурлага байна. Энэ нь “Их хүрээний ая эгшгийн уг гарал”-д буй энэ зурлагатай, энэ нь “Их хүрээний ая эгшгийн уг гарал”-д буй энэ зурлагатай төстэй байна. Харин энэ зурлага нь өргөөд шууд буулгахыг илэрхийлж байгаа бололтой.

- Найруулгыг нь ажиглавал ихэвчлэн нэг өнгөн дээрээ шулуун татсан байна. Өөрөөр хэлбэл татах нь их цохих, нугалах, өргөх, буулгах нь бага байна. Харин “Зүүн хүрээ Дашчойлин хийд”-ийн сударт цохих, нугалах, өргөх нь бусдаасаа их байна. Энэ нь найруулга нь ялгаатай болохыг илэрхийлж байна. Үүнийг цаашид найруулгын дэгтэй нь холбон судлах, тухайн дэгийн бүх судрын найруулгыг бүхэлд нь шинжлэн үзэж харьцуулах зэрэг ажил хүлээгдэж байна.

Abstract

The rituals of wrathful deities, such as Ten Dharmapalas and praises of ten-direction and three-hour deities, such as Buddha Shakyamuni are recited from the third spread of Buddhism. In addition, their melodies were noted with special signs and symbols. Researches and surveys on the Buddhist melody-reciting are not much. Especially, there are few researches focusing to melodies in connection to its composition and notation. So, I tried in this article to study the melodies of Mahgal's “Urin Zallaga” with regard to its composition and notation. I chose some parts of scriptures of the wrathful deities of “Shankhin Baruun Khuree Monastery”, “Gandan Tegchenling Monastery”, “Lama Gegeen Monastery” and “Zuun Khuree Dashchoilin Monastery” as the main sources.

Номзүй

- Агваангунгаасодном.** 2014. *Хөгжмийн шастир саруул оюунтны сэтгэлийг булаагч үйлсийг огоотод түгээгч.* Орч. С.Гантөмөр Уб.,
- Баясгалан Ш.** 2011. *Арван хангал бурхдын тахилга.* Уб.,
- Даваасүрэн Д.** 2013. *Эгшиг тэмдэглэгээг түлхүүрдэх боломж ба хэдэн мэдээний утга. СУИС-ийн Эрдэмтдийн их семинар.* Уб., 177-185
- Төвшинтөр Г., Соронзонболд Б.** 2013. *Махагалын их урин заллагын их ян Ганганлам.* “Ян-ег нь Монголын уламжлалт эгшиг тэмдэглэгээ мөн болох нь” эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхэтгэл, Уб., 57-63
- Төвшинтөр Г.** 2019 . “Махгалын уншлагын ян татах ёсыг хөгжмийн онолын үүднээс судлах нь” сэдэвт магистрын зэрэг горилсон бүтээл. Уб.,
- Эртний дуу хөгжмийн хэдэн зуун ая аялгууг уран бүтээл, эрдэм шинжилгээ, судалгааны эргэлтэд оруулах нь сэдэвт суурь судалгааны ажлын тайлан.* 2015. Уб.,